



2023

*III ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН*

WWW.MLHOLDING.MN

MSE : MLG



АГУУЛГА

- Эрхэм зорилго, алсын хараа
- Компанийн тухай
- Группийн өсөлтийн зураглал
- Гүйцэтгэх захирлын улирлын дүгнэлт
- 2023 оны онцлох тээвэр, ажлууд
- Үйл ажиллагааны тайлан
- Монложистикс Холдинг IPO тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар





ЭРХЭМ ЗОРИЛГО



Дэлхий рүү тэмүүлэх
үндэсний брэнд

АЛСЫН ХАРАА



Монгол Улсыг Ази,
Европыг холбосон
ложистик төв
болгоно.

ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр
чадвартай,
мэргэжлийн
хамт олон



Инновацлаг
багийн
сэтгэлгээ



Бусдыг
хүчирхэгжүүлэх
манлайллын
соёл



Хариуцлага,
сахилга бат



Ил тод
байдал

МОНЛОЖИСТИКС ГРУПП



МОНЛОЖИСТИКС ВОРЛДВАЙД ХХК
Олон улсын тээвэр зууч



МОНЛОЖИСТИКС КАРГО ХХК
Олон улсын карго тээвэр



МОНЛОЖИСТИКС ТРАНЗИТ ХХК
Монгол Улсаар дамжин
өнгөрөх тээвэр



МОНЛОЖИСТИКС ТРАКИНГ ХХК
Олон улсын авто тээврийн
үйлчилгээ



МОНЛОЖИСТИКС ТРАНС СЕРВИС ХХК
ОХУ-д тээврийн үйл ажиллагааг
зохион байгуулагч



КАУС АУСТРАЛИС ХХК
Уул уурхайн бүтээгдэхүүн экспортын
тээвэр зохион байгуулагч



**МОНЛОЖИСТИКС РОССИЯ
ХОЛДИНГ ХХК**
ОХУ-д тээврийн үйл ажиллагааг
зохион байгуулагч



МОНЛОЖИСТИКС ЭКСПРЕСС ХХК
Олон улсад байрших агентын
тээвэр



МОНЛОЖИСТИКС ЭКЮЙПМЕНТС ХХК
Хөдлөх бүрэлдэхүүний түрээсийн үйл
ажиллагаа



МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХХК
Толгой компани

КОМПАНИЙН ТУХАЙ

Монложистикс групп нь 2005 оноос эхлэн тээвэр ложистикийн чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд өдгөө 1 толгой компани, 9 охин компани, 200 орчим ажилтан, 163 орны 800 гаруй түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй салбартаа тэргүүлэх зэрэглэлээр ажиллаж байна.

Бид өнөөдөр Монгол улсад тээврийн салбарын онцлог бүрийг шингээсэн 9 охин компанитайгаар Группийн үйл ажиллагааг өргөжүүлэн, Монгол улсын тээврийн салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, эцсийн харилцагч үйлчлүүлэгчиддээ хамгийн чанартай, сэтгэл ханамжтай үйлчилгээг хүргэхээр ажилладаг билээ.

Монложистикс Холдинг ХХК нь өөрийн охин компаниудад Хүний нөөц, Санхүү, Мэдээллийн технологи, Маркетинг, Стратеги, Бизнес хөгжил, Ложистик б чиглэлд олон улсын менежментийн үйлчилгээг чанартай үзүүлэхээс гадна, шинэ бизнес төслийг үргэлж эрэлхийлж, Группийг нэг бодлого, зарчимд зангидаж, нэгдсэн стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг толгой компани

ӨСӨЛТИЙН ЗУРАГЛАЛ

2005.11.27 - 2023.10

МОНЛОЖИСТИКС ВОРЛДВАЙД ХХК



Анх 5 ажилтантай Варьете бизнес төвөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн Монголын тээвэр ложистикийн салбарын анхдагчдын нэг өдгөө 6 охин компани, нийт 150 гаруй ажилтан, гадаад, дотоодын 300 гаруй харилцагч, үйлчлүүлэгчтэй Монложистикс Групп компани болж тэлээд байна.



2010

Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас гаалийн зуучлагчийн эрх авлаа.



2011

Монголын төмөр зам компаниас гаргасан судалгаагаар ачаа импортлогч Top 3 компанийн нэгээр шалгарлаа.



2013

Монголын TOP 150 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.



2015

ISO 9001:2008 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, албан ёсны сертификатыг гардан авлаа. Мөн Олон улсын тээвэр зуучийн ассоциациудын холбооны (FIATA) албан ёсны гишүүнээр элсэв.



2017

Тээврийн TMS 3.0 цахим платформыг хөгжүүлэн, үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.



2019

Монложистикс Холдинг групп компани болж үйл ажиллагаагаа өргөжүүллээ.



2023

Монложистикс Холдинг Компани IPO хийж олон нийтэд нээлттэй компани боллоо.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН УЛИРЛЫН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон уншигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шинэхэн нээлттэй компани болох Монложистикс Групп нь хөрөнгө оруулагчдын харилцааг мэргэжлийн түвшинд авч явах, үйл ажиллагаагаа илүү ил тод, нээлттэй байлгах ажлын хүрээнд та бүхэнд улирал бүр үйл ажиллагааны тайлангаа хүргэж байхаар төлөвлөж байна.

2023 оны эхний 3 улирал Монложистикс Групп төдийгүй, тээвэр ложистикийн салбарын хувьд онцгой үйл явдал арвин, түүхэн өндөр гүйцэтгэлтэй өнгөрлөө. Тээврийн салбарын хэмжээнд импорт, экспорт, транзит чиглэлийн ачаа урсгал түүхэн дээд рекордоо шинэчлэн тогтоож байгаа бол компанийн хувьд IPO амжилттай гаргаж олон нийтэд нээлттэй болохоос гадна ачаа тээврийн тоо хэмжээгээр мөн өөрийн рекордыг шинэчиллээ. Энэ жилийн эхний 3 улирлын байдлаар бид нийт 800 мянган тонн ачааг тээвэрлэсэн нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 171% ийн өсөлтийг үзүүллээ.

Тээврийн салбарын ачаа эргэлт өндөр байдаг 4-р улиралд өмнөх улирлуудын эрчээ алдахгүй өндөр гүйцэтгэлтэй жилийг дуусгах дээр нийт Монложистикчууд ажиллаж байгаа ба мөн үүний хажуугаар жилийн алдаа оноогоо дүгнэж, ирэх 2024 оны стратеги бизнес төлөвлөгөөгөө боловсруулж байна. Тээврийн салбарт бүтээн байгуулалт, хөгжил эрчимтэй явагдаж байгаа энэ сонирхолтой цаг мөчид бид илүү их өсөлтийг бий болгох маш олон боломжуудын дунд амьдарч байна. Бид эдгээр боломжуудыг ажил хэрэг болгох тал дээр төвлөрөн, тодорхой сорилт, эрсдэлүүдийг удирдан, ирээдүйг гэгээлгээр харан эрч хүчтэй, урам зоригтойгоор ажиллаж байна.

Бид өмнөө тавьсан өсөлтийн стратегийг амжилттай хэрэгжүүлж, бүх оролцогч талуудын үнэ цэнийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэх болно. Тун удахгүй болох ээлжит бус Хувьцаа Эзэмшигчдийн Хурал дээр уулзацгаая.

Монложистикс Холдинг ХХК
Гүйцэтгэх захирал **Г.Хишигбат**



ОНЦЛОХ ТЭЭВЭР



monlogistics
TRUCKING

Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын засгийн газраас хэрэгжүүлж буй туршилтын тээвэрт **Монложистикс Тракинг** компани амжилттай оролцлоо.

monlogistics
WORLDWIDE

Монложистикс Ворлдвайд компани 2023/01/28-нд Улаанбаатар хотоос БНХАУ-ын Шижиажуанг рүү анхны уул уурхайн бус бүтэн цуваа /50 чингэлэг/ экспортын ачааг амжилттай хийж гүйцэтгэлээ.

monlogistics
TRANSIT

2023 оны 3 сард БНХАУ-ын Синган боомтоос ачигдсан чингэлэг бүхий галт тэргийг Улаанбаатар хот дахь гаалийн талбайгаас ОХУ-ийн Ворсино өртөө хүртэл реэкспортын горимоор амжилттай тээвэрлэлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Монложистикс Группийн санаачлан зохион байгуулдаг “Ложистикс Форум” арга хэмжээг 2 дах жилдээ 2023 оны 5 сарын 4 нд амжилттай зохион байгууллаа.



Монложистикс Группийн хамгийн ууган компани Монложистикс Ворлдвайд ХХК-ийн БлюМон оффис 2023 оны 5 сарын 24 ны өдөр “Улаанбаатар хотын хамгийн таатай оффис”-р шалгарлаа



Монложистикс Холдинг Компани IPO хийж олон нийтэд нээлттэй компани боллоо.



Монложистикс Групп болон Ч.Ганжавхлан нарын хамтран хэрэгжүүлж буй “Do Good Hub” сайн дурын нэгдсэн төв 9 сарын 8-ний өдөр албан ёсны нээлт хийж үйл ажиллагаагаа эхлүүллээ. #Илүү_тодоор_нөлөөлье



Монложистикс Группийн цахим худалдааны бизнес болох Cheerah брэнд өөрсдийн гар утасны аппликейшнийг олон нийтэд танилцуулж хэрэглээнд нэвтрүүлээ.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/




2023 оны 3-р улиралын байдлаар тээврийн салбарын орлого 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 87% өссөн байна.

* Салбарын орлого 2023 оны 6-р сарын тоонд үндэслэн дотоод судалгаа болно


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР/



Монложистикс группийн нийт орлого 150 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 50% өссөн байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/





Тээврийн салбарын 2023 оны 3-р улирлын байдлаар нийт ачаа тээврийн эргэлийн хэмжээ 73.8сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 84% өссөн байна.

МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




Монложистикс группийн ачаа эргэлт 800 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 171% өсөж, өмнөх жилийн нийт дүнгээс 102%-иар давсан үзүүлэлттэй байна.



ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/




ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ /МЯНГАН ТОННООР/





МОНЛОЖИСТИКС IPO ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалгын дүн

11,322.9 сая

Захиалгын тоо

1,307 хүн

Биелэлтийн хувь

103.1 хувь

Онцлох 1

Хөрөнгө оруулагчдын дундаж нас 35 Хамгийн залуу хөрөнгө оруулагч 1 настай.

Онцлох 2

Өмнөд Судан улсаас “Энхийг сахиулагч цэрэг” хөрөнгө оруулалт хийв.

Онцлох 3

БНХАУ-ын 3 хувь хүн хөрөнгө оруулав.





“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

—
Хурал болох огноо, цаг:
2023 оны 11-р сарын 18-ны 14:00 цагт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “Монложистикс Холдинг” ХХК

Хаяг: Цахим холбоосоор <https://hural.mlholding.mn>

Хурал болох огноо, цаг: 2023 оны 11-р сарын 18-ны өдрийн 14:00 цагт

Хурал зохион байгуулах хэлбэр: Зайнаас буюу цахим хэлбэрээр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 10-р сарын 23-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, томилох;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны төсвийг батлах;
4. Гол ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд опцион гаргах зөвшөөрөл олгох;





monlogistics
HOLDING

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

info@mlholding.mn

www.mlholding.mn

1101, Нью Хоризонс оффис, Олимпын гудамж, 1-р хороо,
СБД, Улаанбаатар, Монгол Улс

